



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 1185

Баян-Овоо

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 10 дугаар тогтоолын 05 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардалд тусгагдсаны дагуу ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх ажлын зардал гарган зарцуулсугай.

2. Улсын тусгай хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөөнд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын 3.500.000 (Гурван сая таван зуун мянган) төгрөгийг байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаас зохих журмын дагуу гарган зарцуулахыг нягтлан бодогч (С.Нандинцэцэг)-т даалгасугай.

3. Дээрхи ажлын гэрээг Онон-Балжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны мэргэжилтэн (Д.Мөнгөнцэцэг)-тэй байгуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Гэрэлмаа), зарцуулалтын дагуу тайлагнаж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Д.Батзориг) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХ-ОД

010000214